

**ИХ МОНГОЛ УЛС: “ЖАНЖЛАЛЫН ТОГТВОРТОЙ  
БАЙДАЛ”-ААС “ХЭТ ТЭЛЭЛТ” РҮҮ  
ТҮҮХЭН ҮЗЭГДЛИЙН СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛЫН АСУУДАЛД**

*Ч.Болдбаатар\*, Д. Мөнх-Очир\*\**

**Д**элхий дахин, бүс нутгийн түүхэнд Их Монгол улс, монголчуудын гүйцэтгэсэн үүргийг өнөөгийн өндөрлөгөөс, өнгөрсөн найман зууны турш хүн төрөлхтний туулж өнгөрүүлсэн замналын ололт, сургамжийн үүднээс тайлбарлаж бодитой, тэнцвэртэй дүгнэлт гаргах нь их ойд зориулж судлаачид бидний хийж эхлүүлэх нэгэн гол ажил мөн. Энэхүү илтгэлээр бид Их Монгол улсын түүхэн үүргийг олон улсын харилцааны үзэгдлийнх нь хувьд ялимгүй “эдүгээчлэн” тайлбарлах оролдлого хийснээр Монголын түүхийг судлахад гарч ирсэн болон гарч болзошгүй аливаа туйлширсан хандлагууд, тухайлбал, марксист түүх бичлэг дэх сөрөг үнэлэлтээс төдийгүй үндэсний бахархал, хөөрлийн шинжтэй, эераг талыг хэт баримталсан үзлээс ч хөндийрэхийг хичээсэн болно.

Тухайлан, Их Монгол улсын түүхэн үүрэг, түүхэн замналд холбогдох хоёр зангилаа асуудлыг хөндөж тавихыг зорьж байна. Эдгээр нь нэгдүгээрт, тухайн үеийн дэлхий дахины системд Их Монгол улсын гүйцэтгэж ирсэн жанжлал буюу гегемоний үүргийг хэрхэн ойлгож, үнэлж болох, хоёрдугаарт, хэдий зуун дамнан оршин тогтнож, мандан бадарч байсан ч аливаа аугаа бүтцийн нэгэн адил тавилангаар задран бутарч, улмаар замхран сарнихад хүргэсэн систем хүчин зүйлсийн талаар ямар таамаглал дэвшүүлж болохыг толилуулахыг хичээв. Чингэхдээ олон улсын харилцааны онолын зарим томъёоллыг орчин үеийн утгаар нь авч хэрэглэн, түүхэн үзэгдлийг тайлбарлахад ашиглаж болно гэж үзлээ.

Олон улсын харилцааны субъектыг Вестфалийн систем дэх үндэстэн-улсаар төлөөлүүлэн авах нь судалгааны түгээмэл аргачлал мөн боловч Вестфалиас өмнөх үеийн

\* Монгол Улсын Боловсролын Их Сургууль

\*\* Монгол Улсын Их Сургууль

субъектүүдын харилцааг жишээ болгон авч үзэх нь түгээмэл. Үүний жишээ болгож Фукидидын “Пелопоннесийн дайн”-ы түүхийг дурдаж болно. Энэхүү зохиолыг олон улсын харилцааны дэглэм, бодлогын сонголтуудын жишиг үзэгдэл болгон тайлбарлах нь бий.

Судалгааны энэхүү аргачлалыг дэлгэрүүлэн тайлбарлая.

Өдгөөгийн улс төрийн шинжлэх ухаан, түүний хавсарга ухаан болох олон улсын харилцааны хийгээд аюулгүй байдлын судлалд “улс” хэмээх ухагдахуун орчин үеийн утгаар буй болсон огноог 1648 оноор хатуу тогтоож, түүнээс нааших олон улсын харилцааны тогтолцоог Вестфалийн хэмээн нэрийдэх нь бий. Гэвч энэ бол асуудлын хялбаршуулсан тавил бөгөөд өнөөгийн ойлголтоор олон улсын харилцааны үндсэн элементүүд хэрхэн, хэзээ бүрэлдсэн талаар маргаантай олон санал байдаг. Вестфалийн энхийн гэрээ нь Макс Веберийн ангиллын дагуу эрх мэдлийн легитимт байдлын уламжлалт ба харизматик хэлбэрээс рациональ хэлбэрт шилжсэн зурвас үеийн зааг мөн (Weber 1946) бөгөөд бие хүн-төвт төр-улсыг (individual-centered state) нутаг дэвсгэрт үндсэн-улсаар (territorial nation-state) халах түүхэн явцын эхэн байсан нь гарцаагүй. Гэсэн хэдий ч, “төр” хэмээх ухагдахуун XVII зууны Умард Европоос өмнө ба ангид оршин байсан нь ойлгомжтой бөгөөд нутаг дэвсгэрийн, төрийн легитимт чанарын тодорхой шинж чанарууд өгүүлэн буй үеэс өмнө Өрнө дахины сэтгэлгээ, харилцааны түүхэн хувьсал, ялангуяа сэтгэлгээний түүхийг ихэнх судлаачид Вестфалийнхаас өмнөх үед, тодруулбал, эртний Газар дундын тэнгисийн жанжлалын үетэй холбон үздэг.

Өнөөгийн олон улсын харилцааны судлаачид доторх реалист сургуулийг баримтлагчид реалполитикийн үндсийг сонгодог утгаараа Афин, Спарта хоёр болон тэдгээрийн холбоотнуудын хооронд дэгдсэн Пелопоннесийн дайнаар тавигдсан гэж үзэж, энэ үеийн улс хоорондын харилцааны системийг хот улсуудын хоорондох хоёр талын холбооны цогц нийлбэр бөгөөд нэгдсэн тогтолцоо үгүй анархи бүтцийн сонгодог загвар байсан гэж үздэг. (Gilpin 1981) Энэхүү үзэл санаа Афины жанжин, түүхийн гүн ухаанч Фукидид (МЭӨ 471-400)-ийн “Пелопоннесийн дайн” хэмээх алдарт бүтээлээс үүдэлтэй ба тэрээр хот-улсуудын тус тусын ашиг сонирхол, тэдгээрийн нийтлэгжих байдлыг цагаатган, зорилгодоо хүрэхийн төлөө эвсэлдэн нэгдэхийг зөвтгөсөн нь өнөөгийн реалполитикийн гүн ухааны үндэс байсан гэлтэй (Riotti et al. 1993).

Тэгвэл идеалист сургуулийг баримтлагчид Pax Hellenica, Pax Romana үзэл санааг хамтын ажиллагаа, олон улсын харилцаан дахь прогрессист дэглэмийн анхдагч нь байсан гэж үзээд “нэгдсэн дэг журам”, түүнээс улбаалан хамтын аюулгүй байдлын тухай ойлголт хэрэгжиж эхэлсэн гэж ойлгодог. Тиймээс “төр” хэмээх ухагдахуун цэргийн ардчиллын хүрэнээс хальж, “полис”-ын хэлбэрийг олсон тэр цагаас Өрнө дахинаа олон улсын харилцааны хоёр үндсэн парадигм болох хүч тэнцвэржүүлэх (balance of powers) болон аялдан дагалдах (bandwagoning) бодлого хэрэгжиж, сөргөлдөх урсгал болон төлөвисөн гэж үзэж болох юм.

Чингэж үзвээс Их Монгол улсыг хүн төрөлхтний түүхийн үзэгдлийнх нь хувьд эдүгээчилж, орчин үеийн олон улсын харилцааны дэглэмийн судалгааны аргачлалын хүрээнд, энэхүү аргачлалд хэрэглэгдэх зарим нэр томъёог ашиглан, тэдгээрээр дамжуулан тухайн үеийн дэлхийн систем, түүн доторх монголчуудын үүрэг ролийн талаар өөрийн таамаглалыг дэвшүүлэхэд харшлах зүйлгүй мэт.

Их Монгол улс монголчуудын дэлхий дахинаа гүйцэтгэсэн үүргийг даяаршлын үндэс суурийг тавьсан хэмээх тайлбар сүүлийн жилүүдэд өрнө дахины ба Монголын эрдэмтдийн дунд дэлгэрч, XIII-XIV зууны үеийн Монголын түүхийг тайлбарлах сөрөг хандлагыг халж буй нааштай чиг хандлага гэдгийг дурдах хэрэгтэй (Weatherford 2004, Болдбаатар 2002, Баабар 2006). Энэхүү илтгэлээр даяаршлын үүднээс тайлбарлах “Монголын зуун”, *Pax Mongolica* гэж томъёолон хэвшээд буй эл парадигмуудыг дэлгэрүүлэх, тэдгээрийг дахин давтах зорилго агуулсангүй, нөгөөтэйгөөр, эдгээр нь Их Монгол улсыг үзэгдлийнх нь хувьд онцлог, мөн чанарыг нь тайлбарлаж байгааг хөндөлгүй орхиж, үзэгдлийн үүслийн шалтгаан, систем дэх байр суурийг нь тодруулах зорилго агуулсан болно. Түүнчлэн даяаршлын парадигм нь нэг талаас мөнөөх үзэгдлийн гадаад орчинд нөлөөлсөн үр дүнг үнэлж байгаа хэдий ч үзэгдлийн үндэс шалтгааныг гадаад орчноос бус дотоод орчноос, персоналист болон культуралист хүчин зүйлсээс эрэлхийлдэг ба нөгөө талаас, судалгааны бус зориулалтаар хэрэглээний эргэлтэд орохдоо дээр өгүүлсэн априорист хандлага, түүхийг хэт эерүүлэх, туйлширсан үндсэрхэх үзлийн нэгэн ёсны “хэрэглүүр” болох хандлага ажиглагдаж байгааг ч үгүйсгэж болохгүй юм.

Үүнээс үүдэн гарах асуулт бол, тухайн зуун дахь субъект хоорондын харилцааны ямар дэглэм үйлчилсэн, ямар гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөр XIII-XIV зуун нь бүхэлдээ “Монголын зуун” болж, дэлхий дахин Монголоор амьсгалж байв аа гэсэн манай түүхийн нэгэн чухаг зангилаа асуудал юм.

Бидний зүгээс “гегемони” буюу “жанжлал” гэж монголчлогдох нэр томъёогоор өгүүлэн буй үеийн Монголын төр, монголчуудын үүрэг ролийг тайлбарлаж болно гэсэн саналыг дэвшүүлж байна. Чингэхдээ хэт их гүрний жанжлал дор оршин тогтнох системийн тогтвортой байдал, түүний онцлогийг илүү товч байр сууринаас тодорхойлох тийм аргачлалыг сонгон авахыг санал болгож байна. Үүний тулд мөнөөх “жанжлалын тогтвортой байдал”-ын онолын талаар болон жанжлагч хүчний тодорхойлолтуудыг өгөх шаардлагатай болно.

Жанжлалын тогтвортой байдлын онол нь олон улсын улс төр, эдийн засгийн систем, геополитикийн орчинг үүсгэх, хадгалах шалтгаануудыг тайлбарладаг. Энэхүү онолыг анхлан 1929 оны хямралын үндсийг тайлбарлах, түүнээс гарах арга замыг эрэлхийлэх зорилгоор Чарльз Киндлбергер боловсруулсан бөгөөд жанжлагч гүрэн зайлшгүй хэрэгтэй гэсэн санааг дэвшүүлжээ. Олон улсын системд тогтвортой байдал бий

болгохын тулд, ялангуяа худалдаа, хөрөнгийн урсгалыг нийтийн буюу оролцогч талуудын дийлэнхийн ашиг сонирхолд нийцүүлэхийн тулд сонгодог анархи загвараас татгалзах хэрэгтэй бөгөөд дэлхийн ситемийг тодорхойлогч хүчний үүрэг асар их нөлөөтэй хэмээн томъёолсон байдаг (Waltz 1993). Нөгөөтэйгөөр, жанжлагч гүрэнд өөрт нь ашигтай байх бозлол хангагдсан байх ёстой ажээ. Энэхүү онолын практик дахь биелэлтийн тод жишээ бол дэлхийн хоёрдугаар дайны дараах АНУ бөгөөд улс төр, цэргийн хүчин чадлын хувьд хэдий ЗХУ-тай тэнцвэр барьж ирсэн ч Бреттон-Вудсын тогтолцооны ачаар дэлхийн эдийн засгийн гол судсыг атгаж ирсэн нь өдгөө хэт их гүрэн болох үндсийг нь тавьсан гэж үздэг. Жанжлалын тогтвортой байдлын онол ийнхүү Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш нэлээд хөгжиж, зарим судлаачдын хувьд олон улсын системийн дүр төрхийг илүү бодитойгоор тайлбарласан гэгдэх болсон байхад заримынх нь хувьд империализмыг цагаатгах, зөвтгөх үзэл суртлын хэрэглүүр болсон хэмээн шүүмжлэгдсээр иржээ.

Бидний үзэж буйгаар энэхүү онолын үндсэн тодорхойлолтуудыг ашиглан XIII-XIV зууны дэлхий дахины байдлыг олон талаар дүгнэж болох мэт. Жанжлалын онолын голлох төлөөлөгчдийн нэг Роберт Коэны томъёолсноор, аливаа хүчин жанжлагч байхын тулд нэгдүгээрт, олон улсын дэг журам, хэм хэмжээг бий болгох, түүнийг тулган хүлээлгэх чадамж, хоёрдугаарт, чингэх хүсэл эрмэлзэл, гуравдугаарт, эдийн засаг, технологи, цэргийн илт давамгай байдал гэсэн гурван чадавхийг нэгэн дор агуулсан байх ёстой аж (Keohane 1989). Эдгээрийн аль нэг нь дутмаг буюу алдагдсан тохиолдолд ердийн их гүрний статусыг эзэмших хэдий ч дэлхий дахины жанжлалын систем бий болохгүй, эс бөгөөс хэрвээ ямар нэгэн тохиолдлоор буюу хөндлөнгийн хүчин зүйлийн үйлчлэлээр жанжлал бий болдог юм гэхэд тэр нь тогтвортой байдал үүсгэхгүй гэж үздэг.

Энэ онолын дагуу жанжлал үүсэхэд зөвхөн дотоод биш, гадаад хүчин зүйлийн үйлчлэлийг түлхүү авч үздэг. Өөрөөр хэлбэл, аливаа улсын хүчин чадлын эх үүсвэр нь дотоод нөөц бололцоо байдаг гэдгийг үгүйсгэдэггүй ч чухам жанжлалын систем бий болохын тулд гадаад таатай нөхцөл илүү нөлөөлнө гэж үздэгээрээ онцлогтой. Гадаад таатай нөхцөл гэдэгт улс төр-геополитикийн хувьд өмнө нь оршин байсан системийн хямрал, бусад өрсөлдөгч хүчнүүдийн тарамдсан, сул дорой байдал, эдийн засгийн хувьд хэт протекционист, хяналт бүхий хаалттай дэглэм ноёлж буй үед дээр өгүүлсэн гурван шинжийг агуулсан хүчин гарч ирэх нь жанжлалын тогтвортой системийг буй болгодог

аж. Тухайлбал, жанжлалын онолыг шүүмжлэгчид Дэлхийн хоёрдугаар дайны дараах АНУ тэргүүтэй өрнөдийн ертөнцийн давамгайллыг АНУ-ын дотоод хүчин чадалтай гэхээсээ илүү дайнаас үүдэлтэй системийн хямралтай холбон тайлбарладаг, гэвч энэ нь уг онолыг үгүйсгэх бус, харин тодотгох үүрэг гүйцэтгэж ирснийг дурдууштай.

XIII зууны эхэнд дэлхийн байдал үндсэндээ жанжлал бий болж, түүний үндсэн дээр тогтвортой байдал үүсэн бүрэлдэх урьдчилсан нөхцөл хангагдсан, тийм хэрэгцээ байсан гэж дүгнэж болохоор байна. Загалмайтны аян дайны эхний үе шатанд Ойрхи Дорнодоор дамжин Европ-Азийг холбож байсан худалдааны зам хаагдаж, тогтворгүй байдал үүссэн, Өрнө дахины олон улс орон, Орос, Хятадад улс төрийн нэгдсэн захиргаа алдагдсан бөгөөд шашин-үзэл суртлын сөргөлдөөн хямралын гол өөтгөгч нь болж байв. Нэг талаас системийн шаардлага, нөгөө талаас монголчуудын хүчирхэгжилт, түүнтэй нэгэн зэрэг шахам явагдсан Евразийн голлох хүчнүүдийн доройтол зэрэг нь Монголын жанжлал дор зуун дамнасан тогтвортой байдал үүсэн бүрэлдэх нөхцлийг бүрдүүлж өгчээ.

Академич Ж.Болдбаатар: ... *Шинэ тулгар Монгол улс цаашид улам дэвэжин дээшлэх үү, эсвэл тэгэхийгээд бууран доройтох уу гэдэг нь улс орныхоо хил хязгаарыг тэлж өрсөн ирэх аюулаас хэрхэн өөрийгөө хамгаалахаас шууд шалтгаалж байв. Чингис хаан, түүнийг залгамжлагчид өрнө, дорно зүгт аян дайн хийж, дэлхийн талыг эзэлсэн их гүрэн байгуулсан юм. Тэдний байлдан дагуулал нь чухам хэн нь хэнийгээ вэ? гэж байсан тухайн цаг үед гадаад байдлаа төвшитгөх үндсэн арга болж байжээ ...* гэж дүгнэсэн нь жанжлалын тогтвортой байдлын онолын үндсэн постулатыг Монголын түүхийн эл үеийг үзэгдлийн хувьд тайлбарлах боломжтой гэдгийг давхар нотолж байна (Болдбаатар, 2002). Харин “хэн нь хэнийгээ вэ” гэдэг загвар нь зөвхөн дундад зууны үзэгдэл биш, ерөөс олон улсын систем дэх сонгодог анархист дэглэм бөгөөд бидний амьдарч буй зуунд ч нэгэн адил хамаардгийг дурдууштай бөгөөд үүнд жишээ болгож Их Британийн Ерөнхий сайд Т.Блэрийн томъёолсон “хориглолтын сүүлчийн шугам нь давшилтын тэргүүн шугам байх ёстой” гэсэн мэдэгдлийг эш татаж болно (Krauthammer, 2004). Чингэж үзвээс Их Монгол улс бол зөвхөн түүхэн үзэгдэл төдийгүй олон улсын харилцааны эрт, эдүгээгийн судлах зүйлийн хувьд одоо ч үнэ цэнээ алдаагүй үзэгдэл юм.

Үүнтэй холбоотойгоор, эзэнт гүрний задралд нөлөөлсөн хүчин зүйлийн талаар мөнөөх жанжлалын онол дээр тулгуурлан бас нэгэн таамаглал дэвшүүлэхийг хүсч байна. Жанжлалын тогтвортой байдлын онолд “хэт тэлэлт” хэмээх нэр томъёо байдаг. Аливаа

гегемон дээр өгүүлсэнчлэн системийг тогтвортой байлгах, өөрийн манлайллыг хадгалахын тулд хоёр болзлыг заавал анхаардаг ба нэг нь жанжлал, түүнээс үүдэн буй болох тогтвортой байдал ямагт өөрт нь ашигтай байх ёстой, эс тэгвээс жанжлагч уг системийг өөрөө нураадаг, нөгөө нь, жанжлагч хүчин өөрийн давуу тал, тогтвортой байдлыг хадгалахын тулд идэвхтэй давшилтаас өөр аргаар системийг тогтоон барих боломжгүй тийм байдалд аяндаа хүрдэг (Kennedy, 2001). Хоёрдахь тохиолдолд эзэнт гүрний "хэт тэлэлт" буюу жанжлагч хүчний өөрийнх нь хувьд рационал шаардлагаас давсан хэдий ч системийн эрх ашгийн тулд зайлшгүй шаардагдсаар байх тэлэлтийг хийхээс өөр арга зам үлддэггүй. Энэ хоёр болзлын аль нь ч эцсийн дүндээ жанжлалын уналт, системийн задрал, улмаар шинэ хямралд хүргэдэг ба үнэхээр ч XV зуунаас эхлэн дэлхий дахинаа системийн шинэ хямрал нүүрлэсэн нь Монголын жанжлалын дараах хямрал мөн төдийгүй, шинэ манлайллыг төрүүлэх шаардлагыг буй болгосон. Харин Их Монгол улсын түүхэнд жанжлалын хоёр парадоксын нэгдэх нь буюу өөрт ашигтай болж ирсэн тохиолдолд гегемон гүрэн өөрийн манлайллыг эвдэх, задлах үзэгдэл байсан эсэх нь эргэлзээтэй. 1260-аад оноос хойш эзэнт гүрний бүрэлдэхүүн хэсгүүд хэрэг дээрээ нэлээд автономи бүхий улс болж нэгдэл саармагжиж эхэлсэн үзэгдэл нь гадаад хүчин зүйлийн нөлөө, төвөөс зугатах хүчний үйлчлэл үү, эсвэл Зүүн Азийн төвлөрөл бүхий уламжлалт их гүрэн байгуулах гэсэн Хубилай, түүнийг залгамжлагчдын бодлогын үр дүн, улмаар гегемон өөрөө ашиг сонирхлын тэнцвэрээ тооцоолон хийсэн алхам уу гэдгийг ул суурьтай нээн илрүүлэх нь түүхийн судалгааны нэгэн сонирхолтой хийгээд шинэлэг сэдэв болох болов уу.

*Ашигласан ном*

1. Болдбаатар Ж. 2002 *Үлэмжийн их Чингис хаан ба Монгол Улс*, УБ.
2. Баабар Б. 2006 *Монголчууд: Нүүдэл, суудал*, УБ.
3. Gilpin, Robert 1981 *War and Change in World Politics*, Cambridge.
4. Kennedy, Paul 2001 *The Rise and Fall of the Great Powers*, Vintage.
5. Keohane, Robert O. 1989 *International Institutions and State Power: Essays in International Relations Theory*, Boulder, Westview Press.
6. Krauthammer, Charles 2004 "In Defense of Democratic Realism," in *The National Interest*, Issue 77.
7. Thucydides: "The Melian Dialogue," in Paul R. Viotti and Mark V. Kauppi 1993 *International Relations Theory: Realism, Pluralism, Globalism*. Macmillan Publishing.
8. Waltz, Kenneth N. 1993 'The Emerging Structure of International Politics', *International Security*, 18 (2) Fall.
9. Weatherford, Jack 2004 *Genghis Khan and Making of the Modern World*, N.Y..
10. Weber, Max: "The Sociology of Charismatic Authority," in Gerth and Mills, ed. 1946 *From Max Weber: Essays in Sociology*, Oxford University Press.